

“Мэдээлэл, технологийн үндэсний парк”-ын
Захирлын 2021 оны 17-дугаар сарын 30 өдрийн
17-07 тоот тушаалын 1.1 хавсралт



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ИНЖЕНЕРИЙН ШАЛГАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү шалгалтын журам нь Япон улсын Мэдээллийн технологийг дэмжих агентлаг болон Мэдээлэл, технологийн үндэсний парк хооронд байгуулсан харилцан хүлээн зөвшөөрөх гэрээг үндэслэн Мэдээллийн технологийн инженерийн шалгалтын зохион байгуулалт, үүрэг, хариуцлагатай холбогдох харилцааг зохицуулна.
- 1.2. Журмын биелэлтэд холбогдох хэлтэс, газар, төвийн дарга хяналт тавина.
- 1.3. Шалгалт нь жилд 2 удаа, цаасан хэлбэрээр зохион байгуулагдана.

Хоёр. Шалгалтын бүртгэл

- 2.1 Бүртгүүлэхийг хүсэгчид Мэдээлэл, технологийн үндэсний парк (цаашид МТҮП гэх)-ын цахим хуудсан дахь э-баннерт хандан өргөдлийн маягтыг бөглөн онлайнаар бүртгүүлнэ.
- 2.2 Бүртгүүлэгч нь Мэдээллийн технологийн инженерийн шалгалтын дараах 3 ангиллаас тохирох түвшинг сонгож бүртгүүлнэ.
 - 2.2.1 Мэдээллийн технологийн паспорт шалгалт (МТПШ)
 - 2.2.2 Мэдээллийн технологийн инженерийн суурь шалгалт (МТИСШ)
 - 2.2.3 Мэдээллийн технологийн инженерийн ахисан түвшний шалгалт (МТИАТШ)
- 2.3 Шалгалтын бүртгэлийн хураамжийг төлснөөр бүртгэл баталгаажих бөгөөд баталгаажсан тухай мэдээллийг бүртгүүлэгчдэд цахим шуудангаар мэдэгдэнэ.
- 2.4 Тухайн бүртгүүлэгчийн шалгалтад орох эрхийг баталгаажуулах албан ёсны баримт нь эрхийн бичиг, шалгалтын 1,2-р хуудас байна. Эрхийн бичиг болон шалгалтын 1,2-р хуудсыг шалгалтад ороход нь бүртгүүлэгчдэд олгоно. Бүртгүүлэгчдэд шалгалт эхлэхээс 5 хоногийн өмнө шалгалтын зөвлөмжийг цахим шуудангаар илгээнэ.
- 2.5 Шалгалтын бүртгэлийн хугацаа шалгалт эхлэхээс 14 хоногийн өмнө хаагдана.
- 2.6 Хэрэв шалгалтын бүртгэлийг цуцлахаар бол МТҮП-т хүсэлт гарган бүртгэлийн хугацаа дуусахаас өмнө бүртгэлийг цуцлуулж болно.

Гурав. Шалгалтын хураамж

- 3.1 Шалгалтын бүртгэлийн хураамж 100'000 /нэг зуун мянга/ төгрөг байна. Бүртгүүлэгч нь шалгалтын хураамжийг МТҮП-ын Голомт банкны 1102099876 тоот дансанд эсвэл бэлнээр тушаана.
- 3.2 Бүртгүүлэгч нь дараах шаардлагыг хангасан тохиолдолд хөнгөлөлт эдэлж болно.
 - 3.2.1 Их, дээд сургуулийн оюутан бол 60%;
 - 3.2.2 Инкубаторын компанийн ажилтан бол 50%;
 - 3.2.3 Хоёр болон түүнээс дээш удаа шалгалтад хамрагдаж байгаа бол 50%;
 - 3.2.4 МОСА-ийн гишүүн байгууллагын ажилтан бол 40%;
 - 3.2.5 Нэг байгууллагаас 10 ажилтан бол 30%, 20 ажилтан бол 40%, 30 болон түүнээс дээш ажилтан бүртгүүлсэн тохиолдолд шалгалтын хураамжийг 50%;
 - 3.2.6 Хамтын ажиллагааны гэрээтэй эсвэл хамтран ажилладаг байгууллагын ажилтанд МТҮП-ын захирлын шийдвэрийг үндэслэн хөнгөлөлт үзүүлнэ.
- 3.3 Бүртгэлийг цуцалсан /журмын 2.6 дахь зүйлд заасны дагуу/ тохиолдолд шалгалтын хураамжийн 75%-ийг буцаан олгоно.
- 3.4 Бүртгүүлэгч нь шалгалтад ороогүй тохиолдолд шалгалтын хураамжийг буцаан олгохгүй, бусдад болон дараагийн шалгалтад шилжүүлэн тооцохгүй.

Дөрөв. Шалгалтын дүн

- 4.1 Шалгалт нь тэнцсэн эсвэл тэнцээгүй гэсэн үнэлгээтэй байна.
- 4.2 МТИСШ болон МТИАТШ-ийн хувьд үдээс өмнөх болон үдээс хойших шалгалтуудад хоёуланд нь тэнцсэн шалгуулагчийг Амжилттай шалгуулагчид тооцно.
- 4.3 Үдээс өмнөх болон үдээс хойших шалгалтуудын аль нэгэнд нь тэнцсэн шалгуулагч нэг жилийн дотор тэнцээгүй шалгалтаа дахин өгч амжилттай дүн үзүүлбэл шалгалтад тэнцсэнд тооцно.
- 4.4 Шалгалтын дүнг шалгалт явагдсан өдрөөс хойш таван 7 хоногийн дараа МТҮП-ын цахим хуудсаар мэдээллэнэ.
- 4.5 Шалгалтын ерөнхий дүнг нийтэд, харин шалгуулагчийн хувийн дүнг зөвхөн тухайн шалгуулагчдад мэдээлнэ.

Тав. Гэрчилгээ олгох

- 5.1 Амжилттай шалгуулагчдад Азийн орнуудын мэдээллийн технологийн мэргэжилтний шалгалтын зөвлөл (ITPEC), Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (ХХМТГ) болон МТҮП-аас хамтран харилцан хүлээн зөвшөөрсөн улс орнуудад хүчин төгөлдөр бүхий гэрчилгээ олгоно.

5.2.1 Гэрчилгээг шалгалтын дүн зарлагдсанаас хойш нэг сарын дотор олгоно.

Зургаа. Бусад

6.1 Шалгалттай холбоотой санал, хүсэлт, гомдлыг МТҮП-ын info@itpark.mn цахим шуудангаар ирүүлж болно.